



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 151

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

**Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Улсын Их
Хурлын 2011 оны 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны 201 дүгээр тогтоолд тус тус заасны дагуу Засгийн газарт нэрлэсэн үнээр худалдах хүсэлт гаргасан боловч хувьцааны төлбөр авч чадаагүй буюу хишиг хувь хүртээгүй иргэдэд хувьцааг нь буцаан эзэмшүүлэн бүртгэхийг “Үнэт

цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ж.Алдаржавхлан)-д даалгасугай.

2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг цэгцэлж баталгаажуулах ажлыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах арга хэмжээ авахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлагад даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг 2015 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлага, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ж.Алдаржавхлан)-д тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Монгол Улсын сайд

М.ЭНХСАЙХАН